

Санхүүгийн салбарын тойм

Энэ оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын эдийн засгийн өсөлт 3 хувьтай гарсан бөгөөд жилийн эцэст ДНБ-ий өсөлтийг АХБ 3%, ОУВС 4.4% байхаар таамаглаад байна.

Эдийн засгийн өсөлт буурахад уул уурхайн бүтээгдэхүүний экспорт буурсан, хөрөнгө оруулалт, импорт хумигдсан зэргээс уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл хумигдсан нь нөлөөлж байна. Үүнийг дагаад санхүүгийн салбарын өсөлт удаашрах, зээл олголт хумигдах зэрэг үр дагавар ажиглагдаж байна.

Гэхдээ “2016 онд Оюу толгойн далд уурхайн хөрөнгө оруулалт эхэлснээр эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлж, 2016 оны сүүл гэхэд ДНБ-ий өсөлт потенциал түвшиндээ хүрэхээр байна”¹ гэж Монголбанк үзэж байна.


Санхүүгийн салбарт эргэлдэж буй хөрөнгийн дийлэнх хэсэг нь банкны салбараар дамжиж байгаа бөгөөд эдийн засгийн нөхцөл байдлыг даган салбарын өсөлт удааширсан.

III улирлын байдлаар нийт зээлийн хэмжээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5.5% буурсан бол хадгаламжийн хэмжээ 0.5% буураад байна.


Мөн чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж, нийт зээлд эзлэх хувь тайлант улиралд 5.5% болж өслөө. Энэ дүн өнгөрсөн онд 2.8% байсан билээ.

Ийнхүү эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой иргэд, бизнес эрхлэгчдийн санхүүгийн үйлчилгээ авах эрэлт, чадамж муудаж байгаа ч банкны салбарын актив, өөрийн хөрөнгө өсөлттэй хэвээр байгаа нь сайн үзүүлэлт болж байна.

Санхүүгийн салбарт оролцогчдын тоо, нийт хөрөнгө, 2У'15



(2У'15, их наяд төгрөг)




¹ Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл, Монголбанк

БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2015 он – III улирал

Банкны салбарын актив, их наяд төгрөг




Салбарын нийт актив 2015 оны III улирлын байдлаар 21 их наяд төгрөгт хүрлээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2% өссөн бол өмнөх улирлаас 2.4% буурсан үзүүлэлт юм.

Нийт активын бүтэц, 3У'15




Нийт зээл, их наяд төгрөг



Активын өсөлтийн хурд нь түүний талаас илүү хувийг бүрдүүлж буй нийт зээлийн өсөлтийн хурдаас шууд хамаардаг. Эдийн засаг харьцангуй удааширч буйтай холбоотой зээлийн хэмжээ ч төдийлөн нэмэгдэхгүй байна. Нийт зээл 11,6 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 5.5% буурсан бол өмнөх улирлаас 0.1% өсөөд байна.

Ипотекийн зээл, их наяд төгрөг




Мөн орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөрийг бууруулах шийдвэр гарсанаар зээлийн хэмжээ нэмэгдэх хүлээлттэй байсан ч тус хөтөлбөр хараахан хэрэгжиж эхлээгүй байна.

Тайлант хугацаанд ипотекийн зээлд нийт 75 мянган иргэн хамрагдаад байгаагаас 54 мянга нь орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт хамрагдсан.

Ипотекийн зээлийн хувьд чанаргүй зээлийн хувь 0.6% байгаа нь зээлийн эргэн төлөлт харьцангуй сайн байгааг илтгэж байна.

Чанаргүй зээл, тэрбум төгрөг



Харин нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь 5.1% болж, өмнөх улирлаас 0.5 нэгж хувиар өсөөд байна. Сүүлийн 7 улирал тасралтгүй өсч буй чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 70%, өмнөх улирлаас 12% өсөөд байна.

Энэ нь банкуудын хувьд анхаарах асуудал болоод байгаа бөгөөд зээлийн шалгуур чангарч буй нь ч үүнтэй холбоотой.

Банкны салбарын үндсэн үзүүлэлтүүд, улирлын өсөлт, хувь

	2013			2014			2015			III
	II	III	IV	I	II	III	IV	I	II	
Активын өсөлт	20.0%	13.9%	14.8%	(0.8%)	3.4%	(2.2%)	7.9%	(8.0%)	5.2%	(2.4%)
Зээлийн өсөлт	16.6%	18.1%	3.1%	5.9%	8.9%	2.6%	(0.9%)	(1.9%)	(2.7%)	(0.1%)
Ипотекийн зээлийн өсөлт	14.2%	56.1%	20.3%	13.1%	11.2%	7.3%	8.6%	6.0%	5.8%	4.0%
Чанаргүй зээлийн хувь	3.7%	5.3%	2.5%	2.6%	2.7%	2.8%	3.1%	3.9%	4.6%	5.1%
Харилцахын өсөлт	22.3%	8.4%	(3.0%)	(10.8%)	8.1%	7.0%	7.5%	(22.3%)	7.3%	(2.2%)
Хадгаламжийн өсөлт	3.3%	5.6%	20.0%	12.5%	(0.8%)	(2.3%)	5.9%	(0.1%)	(0.9%)	(0.4%)
Өөрийн хөрөнгийн өсөлт	11.1%	6.2%	9.3%	41.7%	6.5%	5.4%	10.9%	2.1%	4.7%	3.3%

Банкны салбарын онцлох үйл явдлууд

07.02	Монголбанк <i>бодлогын хүүг</i> өөрчлөхгүй <i>хэвээр хадгалах</i> шийдвэр гаргалаа. Инфляци буурч буй, 2015 оны эхнээс төлбөрийн тэнцэлд эерэг өөрчлөлтүүд гарч буйтай холбоотой ийм шийдвэр гаргажээ. Гэхдээ ГШХО бага, төсвийн алдагдал нэмэгдсэн хэвээр байгаа зэрэг нь мөнгөний бодлогыг зөөлрүүлэх чиглэлд өөрчлөлт хийх боломжийг хязгаарлаж байна.
08.12	Голомт банк анх удаа <i>100% даатгагдсан "Эрчим бонд"</i> -ийг 500 сая төгрөгийн үнийн дүнтэйгээр гаргаж хөрөнгийн зах зээлд арилжааллаа.
08.08	УИХ-ын чуулганы ээлжит хуралдаанаар <i>Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк үүсгэн байгуулах</i> хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн баталлаа.
09.10	Монголын Банкны Холбоо, Монголбанк, арилжааны банкууд, ЮнионПэй Интернейшнл хамтран <i>"Төлбөрийн картын эрсдэлийн Олон улсын зөвлөгөөн-2015"</i> арга хэмжээг зохион байгууллаа.
09.14	<i>Монгол Улсын Хөгжлийн банк Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банкттай</i> 7 жилийн хугацаатай, 20 сая евро хүртэлх <i>зээлийн гэрээг</i> байгууллаа. Энэхүү зээлийн эх үүсвэр нь Монгол Улсын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулагдах ажээ.
09.21	Монголбанк нь Сангийн яам болон Блүүмберг компанитай хамтран Монгол Улсын <i>Засгийн газрын үнэт цаасны өгөөжийн муруйг</i> Блүүмберг терминалд албан ёсоор байршууллаа.
09.24	Санхүүгийн Зохицуулах Хорооноос Голомт банкинд 2014 оны 8 сарын 24-нд Монгол Улсад анх удаа үнэт цаасны зах зээлд Кастодиан банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон билээ. Өнгөрсөн хугацаанд Голомт банк Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж, Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төвтэй хамтран бэлтгэл ажлыг бүрэн хангаж <i>Кастодиан банк албан ёсоор нээлтээ хийлээ.</i>
09.30	<i>Худалдаа хөгжлийн банк</i> Засгийн газрын баталгаатай <i>500 сая ам.долларын бондыг</i> олон улсын хөрөнгийн зах зээлд дахин арилжааллаа.
10.12	Монголбанк нь Канадын Үндэсний Банкныг <i>ХасБанкны шинэ хувьцаа зэмшигчээр</i> бүртгэж зөвшөөрөл олголоо.
10.22	Монгол Улсын Их Хурлын чуулганаар <i>"Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай"</i> УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцлээ.
10.23	Нийслэлийн Мэдээллийн Технологийн газар, МҮХАҮТ, Голомт банк, Баяр агентлаг хамтран зохион байгуулсан <i>"Интернэт худалдааны анхдугаар конференци – Улаанбаатар 2015"</i> чуулган болж өнгөрлөө.

Банкуудын өрсөлдөөний тойм

Арилжааны банкны үндсэн үүрэг нь мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй байгаа хэсгээс хөрөнгийг татаж, дутагдалтай байгаа хэсэгт шилжүүлэн, харилцагчдын итгэл дээр суурилсан санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа үзүүлэх, харилцагчдын хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэх бөгөөд эцсийн зорилго нь санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан ашиг олох явдал билээ.

2015 оны II улирлын байдлаар банкны салбарт нийт 14² арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Монголбанкны тодорхойлсноор системд нөлөө бүхий банкуудад Хаан банк, ХХБ, Голомт банк, Хасбанк, Төрийн банк, Улаанбаатар хотын банк гэсэн 6 банк багтаж байна. Эдгээр банкууд нь системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж буй юм.

Арилжааны банкуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өөрчлөлт хөдөлгөөнийг харуулдаг мэдээллийн гол эх сурвалж бол банкуудын санхүүгийн тайлан юм. Банкуудын өрсөлдөөний тоймыг гаргахдаа санхүүгийн хураангуй тайланг ашиглан дараах үзүүлэлтүүдийг харьцуулсан болно.

Үүнд:

- Нийт актив
- Зээл
- Харилцах, хадгаламж
- Өөрийн хөрөнгө
- Ашиг

Түүнчлэн банкны үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэгч зарим нэг харьцаа, үзүүлэлтүүдийг тооцлоо.

Эдгээр үзүүлэлтээр арилжааны банкуудыг харьцуулахдаа активын хэмжээгээр нь Том-3 банк, Дунд-3 банк, жижиг банкууд гэж ангилсан.



АКТИВ

БАНКУУД


	АКТИВ	БАНКУУД
ТОМ-3 БАНК	>3 их наяд төгрөг	Худалдаа хөгжлийн банк Хаан банк Голомт банк
ДУНД-3 БАНК	1-3 их наяд төгрөг	Хасбанк Төрийн банк Улаанбаатар хотын банк
ЖИЖИГ БАНКУУД	<1 их наяд төгрөг	Капитал банк Чингис хаан банк Капитрон банк Үндэсний хөрөнгө оруулалтын банк Ариг банк Богд банк Кредит банк Тээвэр хөгжлийн банк

² Хадгаламж банк 2013 оны 7 сард Төрийн банктай нэгдсэн. Богд банк шинээр (2014 оны сүүлээр тусгай зөвшөөрлөө авсан) үүсгэн байгуулагдсан.

АКТИВ

Тайлант хугацаанд арилжааны банкуудын нийт активын³ 69 хувь нь Том-3 банкинд төвлөрч байна. Үүнээс активын хэмжээгээр ХХБ тэргүүлсэн бол Хаан, Голомт банкууд удаалж байна.

Зах зээлд эзлэх хувь, активаар, 3У'15




Өмнөх улиралтай харьцуулахад Хаан, Хас банкны зах зээлд эзлэх хувь ойролцоогоор 1% нэмэгдсэн бол ХХБ, Голомт банкны зах зээлд эзлэх хувь тус бүр 1% буурсан байна. Зах зээлд эзлэх хувиа хамгийн ихээр нэмэгдүүлсэн банк нь Хаан банк байна.


Харин активын өсөлтийн хувьд өнгөрсөн жилтэй харьцуулахад Том-3, Дунд-3 банкуудаас Хаан банк активаа хамгийн ихээр өсгөсөн байна. Голомт, Төрийн банкны активын дүн буурсан үзүүлэлттэй байна.

Том, дунд банкуудтай харьцуулахад жижиг ангилалд багтсан банкууд, тухайлбал ҮХОБ, Ариг банкууд активаа илүү хурдтай өсгөж байна. Өөрөөр хэлбэл тус банкууд зээл олголтоо нэмэгдүүлэх тал дээр идэвхтэй ажиллаж байна.


Том-3 банк



Дунд-3 банк



Жижиг банкууд




³ Арилжааны банкуудын санхүүгийн хураангуй тайлангийн нийлбэр дүнгээр тооцов.

ЗЭЭЛ

Банкуудын нийт зээлийн⁴ 67 хувийг Том-3 банк, 25 хувийг Дунд-3 банк, үлдсэн 8 хувийг жижиг банкууд олгосон байна. Активын хэмжээгээр ХХБ тэргүүлж байсан бол зээлийн дүнгээр Хаан банк тэргүүлж байна.

Зах зээлд эзлэх хувь, зээлээр, 3У'15





Өмнөх улиралтай харьцуулахад Хаан банк, ХХБ зээлийн зах зээлд эзлэх хувиа тус тус 0.5, 0.8 нэгж хувиар нэмэгдүүлсэн бол Голомт, Хас, Төрийн банкууд 0.4-0.9 нэгж хувиар зах зээлд эзлэх хувиа алджээ.

Тайлант хугацаанд зээл олголтоо хамгийн ихээр нэмэгдүүлсэн банкууд нь жижиг ангилалд багтсан Ариг, ҮХОБ, Капитал, Кредит банкууд байна.


Харин Том, Дунд банкуудын хувьд зээлийн өсөлтийн хурд харьцангуй удаан, ихэнх банкууд хасах утгатай байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Хаан банк зээлийн дүнгээ ойролцоогоор 2% нэмэгдүүлсэн бол Голомт, Төрийн банк, ХХБ, УБХБ-ны зээл олголт 9-21% буурсан байна.

Том-3 банк

Дунд-3 банк



Жижиг банкууд




⁴ Арилжааны банкуудын санхүүгийн хураангуй тайлангийн нийлбэр дүнгээр тооцов.

ХАРИЛЦАХ БА ХАДГАЛАМЖ

Нийт харилцах ба хадгаламжийн⁵ 67 хувийг Том-3 банк, 26 хувийг Дунд-3 банк, үлдсэн 7 хувийг жижиг банкууд бүрдүүлж байна.

Зах зээлд эзлэх хувь,
харилцах ба хадгаламжаар, 3У'15





Эх үүсвэрийн хэмжээгээр Хаан банк тэргүүлж, ХХБ удаалсан байна. Өмнөх улиралд Голомт банк хоёрт жагсаж байсан бол энэ удаа ХХБ-ний дараа оржээ. Зах зээлд эзлэх хувиа Капитрон банк хамгийн их буюу 1 нэгж хувиар нэмэгдүүлсэн бол Төрийн банк 0.9 нэгж хувиар зах зээлд эзлэх хувиа алджээ.

Харилцах, хадгаламж татан төвлөрүүлэлсэн дүнгээ Ариг банк 2 дахин, ҮХОБ 27%, Капитал банк 15% нэмэгдүүлж чадсан нь хамгийн өндөр өсөлтүүд байлаа.


Харин Төрийн банк, ХХБ болон жижиг ангилалд багтсан ТХБ, Кредит, Чингис хаан банкуудын эх үүсвэр өнгөрсөн жилээс буурсан дүнтэй байна. Богд банк одоогоор харилцах, хадгаламж татан төвлөрүүлээгүй байна.

Том-3 банк

Дунд-3 банк




Жижиг банкууд



⁵ Арилжааны банкуудын санхүүгийн хураангуй тайлангийн нийлбэр дүнгээр тооцов.

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Банкуудын нийт өөрийн хөрөнгийн⁶ 73 хувь нь Том-3 банкинд, 20 хувь нь Дунд-3 банкинд, 7 хувь нь жижиг банкуудад байршиж байна.





Өнгөрсөн улиралтай харьцуулахад Хаан банк зах зээлд эзлэх хувиа 1.3 нэгж хувиар нэмэгдүүлсэн бол ХХБ-ны зах зээлд эзлэх хувь 1.1 нэгж буурсан нь хамгийн өндөр өсөлт ба бууралт байлаа.

Өөрийн хөрөнгөө нэг жилийн дотор ҮХОБ 2 дахин, Капитал банк 59%, ХХБ 51% нэмэгдүүлж чадсан нь хамгийн өндөр өсөлтүүд байлаа.


Харин Чингис хаан, Ариг банк, ТХБ, Хас банкны хувьд өөрийн хөрөнгийн өсөлт хасах утгатай байна.

Том-3 банк

Дунд-3 банк



Жижиг банкууд



(тэр.төг)

⁶ Арлжааны банкуудын санхүүгийн хураангуй тайлангийн нийлбэр дүнгээр тооцов.

ХАРЬЦАА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД


[Зээл/Харилцах ба хадгаламж] харьцаа

Энэ харьцаа нь банкууд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийнхөө хэдэн хувийг зээл болгон гаргаж буйг харуулна.

Хэт өндөр байвал эх үүсвэрийн дутагдалтай буюу дотоодын зах зээлээс татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийн дутагдалтай байх, зээлийн эрсдэл үүсэх, банкууд гадаад эх үүсвэрийг ихээхэн ашиглаж байгааг илтгэнэ. Бага байвал эх үүсвэрийн илүүдэл үүсэх, ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Банкуудын дундажаар энэ харьцаа 106.8% байна. Өөрөөр хэлбэл банкууд харилцах ба хадгаламжаас гадна бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгөөр зээл олгож байна.


Тайлант хугацаанд Голомт, Төрийн банк, Ариг банкууд эх үүсвэрийн илүүдэлтэй байна. Харин бусад банкуудын хувьд энэ үзүүлэлт 100-аас өндөр байгаа нь гаднаас төслийн болон бусад эх үүсвэрээр хөрөнгө орж ирж буйтай холбоотой болов уу.



[Хүүний зардал/Хүүний орлого] харьцаа

Банкуудын үр ашигтай үйл ажиллагааг хэмжих энэхүү үзүүлэлт нь хүүний орлогын хэдэн хувь нь зардал болон гарч буйг харуулна. Бага байвал үйл ажиллагааны зардал бага, ашиг өндөр байна гэж ойлгож болно.

Системийн нийт дүнгээр энэ үзүүлэлт 63.5% байна. Хамгийн хямд эх үүсвэртэй банкууд нь ТХБ, Кредит банкууд байна. Тайлант хугацаанд Хасбанк зардлаа хамгийн их хувиар бууруулж чаджээ.



АШИГТ АЖИЛЛАГАА


Арилжааны банкуудын санхүүгийн тайлангийн нийлбэр дүнгээр⁷ банкууд энэ оны III улиралд нийт 226 тэрбум төгрөгийн ашигтай (татварын өмнөх) ажиллажээ.

Нийт өөрийн хөрөнгө 2.5 их наяд төгрөгт харьцуулбал тайлант улиралд өөрийн хөрөнгийн 100 төгрөг тутамд 8.9 төгрөгийн ашигтай ажилласан байна.


Тайлант хугацаанд Хаан, Хас банкууд хамгийн өндөр ашигтай ажилласан байна. Харин бусад банкуудын хувьд өнгөрсөн жилтэй харьцуулахад ашгийн хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.

Ашгийн хэмжээгээ нэг жилийн дотор хамгийн өндөр хувиар өсгөсөн Хаан банк ашгаа 32 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж чаджээ.


Том-3 банк



Дунд-3 банк



Жижиг банкууд



Эх үүсвэр:

Санхүүгийн болон Банкны салбарын тойм хэсэгт Монголбанк (2013 оны 4 дүгээр улирлаас хойш татан буугдсан банкуудын дүнг хассан статистикийг ашиглав), Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хорооны мэдээллийг ашиглав.

Банкуудын өрсөлдөөний тойм хэсэгт арилжааны банкуудын санхүүгийн хураангуй тайланг ашиглав.

Товчилсон нэрс:

3У'15
ББСБ Банк бус санхүүгийн байгууллага
ГШХО Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ДНБ Дотоодын нийт бүтээгдэхүүн
ОСИСТБ Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр
УБХБ Улаанбаатар хотын банк
ҮХОБ Үндэсний хөрөнгө оруулалтын банк
ҮЦЗЗ Үнэт цаасны зах зээл
ХЗХ Хадгаламж, зээлийн хоршоо
ХХБ Худалдаа хөгжлийн банк

⁷ Арилжааны банкуудын санхүүгийн хураангуй тайлангийн нийлбэр дүнгээр тооцов.